

МУИС-ШУС-ийн Эдийн Засгийн Тэнхимийн бакалаврын судалгааны ажил бичих, хамгаалах журам

МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны журамд (Захирлын 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/256 тоот тушаалын 2 дугаар хавсралт) үндэслэн ШУС-ийн ЭЗТ-ийн Эдийн засаг хөтөлбөрийг төгсөгчдийн бакалаврын судалгааны ажил (цаашид судалгааны ажил гэх) бичих үйл явц, дүгнэх үйл ажиллагааг энэхүү заавраар зохицуулна.

Тус хөтөлбөрт суралцаж буй оюутан нь бакалаврын судалгааны ажил бичих хүсэлт гаргасан улирлыг оруулалгүйгээр мэргэжлийн заавал үзэх хичээлүүдийг амжилттай судлан **115-аас багагүй багц цаг** цуглуулсан, голч дүн **3.3 (B+)**-оос багагүй байгаа тохиолдолд өөрийн хүсэлтээр бакалаврын судалгааны ажил бичиж болно. Судалгааны ажил гүйцэтгэж байгаа улиралд **2-оос ихгүй** хичээл сонгон хамт судалж болно. Бакалаврын судалгааны ажил бичих оюутан дараах хуваарийн дагуу ажиллана.

1. Судалгааны ажил бичих дээрх ерөнхий нөхцөлийг хангасан оюутан нь өөрийн сонирхол, ирээдүйд эрхлэх ажил, мэргэжлийн төлөвлөгөө зэрэгтээ үндэслэн судалгааны ажлын ерөнхий сэдвээ өөрөө тодорхойлох ба сонгосон сэдвийн дагуу удирдах боломжтой тэнхимийн багш нартай биечлэн үулзаж өөрийн судалгааны төлөвлөгөөг танилцуулан зөвлөгөө авах замаар харилцан зөвшилцөж удирдагч багшаа олно.
2. Оюутан нь удирдагч багшийн зөвшөөрөлтэйгөөр өөрийн судалгааны ажлын ерөнхий хүрээг тодорхойлсон байна. Оюутан удирдагч багш, судалгааны ерөнхий нэрийг төгсөх улирлын **III** долоо хоногт багтаан зөвлөх багшид Маягт 1-р өгнө¹. Хэрэв энэ хугацаанд багтаж мэдэгдээгүй бол бакалаврын судалгааны ажил бичихгүйгээр төгсөх хүсэлтэй гэж үзнэ.
3. Эдийн засгийн тэнхимээс гаргасан “Судалгааны ажилд тавигдах шаардлага”, “Бүтээлийн хулгай, бусдаас хуулах, бусдын бүтээлийг өөрчлөхөөс зайлсхийх санамж”-ийг дагаж мөрдөнө.
4. **VIII** долоо хоногт багтаан тэнхимээс тухайн улиралд дипломын ажлыг хамгаалуулах комиссыг 4-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр тодорхойлж бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар томилно. Комиссын нарийн бичгийн дарга нь зөвлөх багш нарын нэг байх ба бүрэлдэхүүний 1/3-ээс багагүй нь өөр тэнхим, сургууль, гадны байгууллагын төлөөлөл байна.
5. **IX** долоо хоногт багтан бакалаврын судалгааны сэдвийн эцсийн нэршил, удирдагч багшийн явцын дүгнэлтийг комиссын нарийн бичигт Маягт 2-р өгнө². Хэрэв энэ хугацаанд өгөөгүй эсвэл удирдагч багш оюутны судалгааны ажил цааш үргэлжлэх боломжгүй гэсэн дүгнэлт өгсөн бол уг оюутныг судалгааны ажил бичих боломжгүйд тооцно. Амжилттай дүгнэгдсэн судалгааны ажлын сэдэвт үндэслэн шүүмжлэгч багшийг комисс томилно.
6. Тухайн улирлын **XIII** долоо хоногт судалгааны ажлын урьдчилсан хамгаалалтыг удирдагч, шүүмжлэгч, комиссын нэг гишүүний бүрэлдэхүүнтэй хийх бөгөөд уг комиссын дүгнэлтэд үндэслэн эцсийн хамгаалалтад орох зөвшөөрлийг Маягт 3-ын дагуу олгоно³. Урьдчилсан хамгаалалт нь оюутан өөрийн судалгааны сэдвээр илтгэл тавьж, асуултад хариулах байдлаар явагдана. Комиссын гишүүдийн олонхын саналаар дүнг тооцох бөгөөд гишүүд тус бүр ижил эрхтэй байна. Хэрэв оюутан урьдчилсан хамгаалалтад хангалтгүй дүн үзүүлбэл судалгааны ажил бичих боломжгүй гэж үзнэ.

¹ Хавсралт 1

² Хавсралт 2

³ Хавсралт 3

7. Оюутан урьдчилсан хамгаалалтаас гарсан санал, зөвлөмж, хүсэлтүүдийг өөрийн судалгааны ажилд тусган тухайн улирлын хичээлийн XVI долоо хоногийн 3 дахь хичээлийн өдөрт (хэрэв бүх нийтийн амралтын өдөр таарвал өмнөх хичээлийн өдөрт) багтаан судалгааны ажил хамгаалуулах комиссын нарийн бичигт өөрийн нэр, удирдагчийн нэр, шүүмжлэгчийн нэрийг судалгааны ажилдаа дурдахгүйгээр хэвлэсэн нэг хувь, нэртэй 2 хувь хэвлэмэл байдлаар хүлээлгэн өгнө. Мөн нарийн бичигт э-мэйлээр явуулсан байна.
8. Нарийн бичгийн дарга хүлээн авсан хэвлэмэл судалгааны ажлуудыг комиссоос томилсон шүүмжлэгч болон хөндлөнгийн уншигч (нэргүй хэвлэсэн хувилбарыг) багш нарт ажлын нэг хоногт багтаан хүлээлгэн өгнө. Удирдагч, шүүмжлэгч, хөндлөнгийн уншигч багш нар нь ажлын хоёр хоногийн дотор судалгааны ажлыг уншиж судлан Маягт 4⁴-өөр өгөгдсөн дүгнэх журмын дагуу тодорхой тайлбартайгаар дүгнэн, эцсийн дүнг комисст хүлээлгэн өгнө.
9. Улирлын шалгалтын I долоо хоногийн эхний 2 өдөрт багтаан бакалаврын судалгааны ажлын эцсийн хамгаалалт явагдах бөгөөд комисс нарийн бичгийн даргаас дүнгийн нэгтгэлийг хүлээн авч, хэлэлцэнэ. Бакалаврын судалгааны ажлын дүнгийн 40 хувь нь удирдагч, 30 хувь нь шүүмжлэгчийн дүн байх ба 30 хувь нь уншигч багшийн дүнгээр тодорхойлогдоно.
10. Хэрэв, дээрх гурван багшийн дүнгийн хоорондын хамгийн их зөрүү 15 онооноос бага бол комисс энэ зааврын 9-д дурдсан байдлаар судалгааны ажлын эцсийн дүнг батална. Хэрэв дүнгийн зөрүү 15 оноо болон түүнээс дээш бол комисс удирдагч, шүүмжлэгч болон уншигч багш нараас дүнгийнх нь үндэслэлийг сонсож, эцсийн шийдвэрийг гаргана.
11. Бакалаврын судалгааны ажлын нэгдсэн дүнг комиссын дарга оюутнуудад эцсийн хамгаалалтын өдөр танилцуулна. Хэрэв судалгааны ажил хамгаалуулах комиссын дүнгийн талаар гомдол, санал гарвал, комисс хэлэлцэнэ.
12. Хангалттай үнэлгээ авсан оюутан ажлын 3 хоногт багтаан өөрийн судалгааны ажлын электрон хувилбар болон ашигласан тоон мэдээллийг нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.
13. Шаардлагатай тохиолдолд энэхүү зааврын заалтуудыг тэнхимийн хурлын шийдвэрт үндэслэн өөрчилж болно.
14. Энэхүү зааврын жил бүрийн календарьчилсан хуваарийг хичээлийн улирал бүрийн нэгдүгээр долоо хоногт багтаан тодорхойлон, төгсөх хүсэлт гаргасан бүх оюутнуудад танилцуулсан байна.

**МУИС-ШУС-ийн ЭЗТ-ийн
бакалаврын судалгааны ажлын календарьчилсан хуваарь**

(Эдийн засаг хөтөлбөрийн оюутнуудад)

2023-2024 оны хичээлийн жилийн Хаврын улирал

№	Хийгдэх ажил	Эцсийн хугацаа
1	Төгсөх хүсэлт өгсөн оюутнуудад журам ба календарьчилсан хуваарийг танилцуулах	2024.02.06
2	Сэдвийн ерөнхий хүрээ ба удирдахыг зөвшөөрсөн багшийн нэрийг зөвлөх багшид мэдэгдэх	2024.02.22
3	Тэнхимээс комиссыг томилох	2024.03.28
4	Сэдвийн нэрийг эцсийн байдлаар, удирдагчийн явцын дүгнэлтийг нарийн бичгийн даргад өгөх	2024.04.04
5	Судалгааны ажлын урьдчилсан хамгаалалт	2024.04.26 - 2024.05.02
6	Судалгааны ажлын эцсийн хувилбарыг удирдагч, шүүмжлэгч, өөрийн нэрийг оруулаагүй байдлаар хэвлэмэл 1 хувь, эцсийн хувилбараар хэвлэмэл 2 хувийг нарийн бичигт хүлээлгэн өгөх. Мөн электрон хувилбарыг илгээх	2024.05.21
7	Удирдагч, шүүмжлэгч, оюутны нэргүй хувилбарыг нарийн бичиг хөндлөнгийн уншигч багшид өгөх	2024.05.22
8	Удирдагч, шүүмжлэгч, уншигч багш нар өөрсдийн үнэлгээг нарийн бичигт бичгээр хүлээлгэн өгөх	2024.05.24 (25, 26 амралтын өдөр)
9	Эцсийн хамгаалалт	2024.05.27

Маягт 1 (III долоо хоногт өгөх)

Судалгааны ажлын ерөнхий нэр, удирдагчийн зөвшөөрөл

№	Асуулт	Хариулт
1	Оюутны овог	
2	Оюутны нэр	
3	Оюутны ID	
4	Элссэн он, хөтөлбөр	
5	Төгсөх хүсэлт гаргасан эсэх, гаргасан улирал	
6	Цуглуулсан нийт кредит (VII улирлын эцсийн байдлаар)	
7	Төгсөх улиралд судалж буй хичээлийн нэр (байхгүй бол - гэнэ)	
8	Дадлага хийж буй эсэх	

Судалгааны ажлын нэр :

Удирдахаар зөвшөөрсөн багшийн нэр, албан тушаал, цол:

Удирдахаар зөвшөөрсөн багшийн гарын үсэг:

Энэ хэсгээс доош зөвлөх багш бичнэ.

Зөвлөх багшид хураалгасан огноо:

Зөвлөх багшийн нэр, албан тушаал, цол:

Зөвлөх багшийн гарын үсэг:

Цаг:

Маягт 2 (IX долоо хоногт өгөх)

Судалгааны ажлын эцсийн нэр, удирдагч багшийн явцын дүгнэлт

Оюутны овог, нэр:

Судалгааны ажлын нэр:

Удирдагч багшийн нэр, албан тушаал, цол:

Явцын дүгнэлт (тус оюутны өнөөдрийг хүртэлх хугацаанд хийсэн судалгааны ажлын үнэлгээ, цаашид судалгааны ажлаа дуустал бичиж урьдчилсан хамгаалалтад оруулах боломжтой эсэхийг дүгнэнэ):

Энэ хэсгээс доош нарийн бичиг бичнэ.

Зөвлөх багшид хураалгасан огноо:

Зөвлөх багшийн нэр, албан тушаал, цол:

Зөвлөх багшийн гарын үсэг:

Цаг:

Маягт 3 (XIII долоо хоногт багтах)

Судалгааны ажлын урьдчилсан хамгаалалтын протокол

№	Асуулт	Хариулт
1	Оюутны овог, нэр	
2	ID, хөтөлбөр	
3	Удирдагч багш	
4	Шүүмжлэгч багш	
5	Комиссын гишүүн	

Судалгааны ажлын нэр:

Дүгнэлт (оюутны ажлыг эцсийн хамгаалалтад оруулахаар шийдвэрлэсэн эсэхийг тодорхой бичнэ. Гишүүн тус бүр санал хэлж олонхын саналаар шийднэ):

Удирдагчийн санал:

Шүүмжлэгчийн санал:

Комиссын гишүүний санал:

Эцсийн дүгнэлт:

(Урьдчилсан хамгаалалтын протоколыг комиссын гишүүн хөтөлж, хамгаалалтын процессыг эхнээс нь дуустал дуу хураагуурт бичиж баталгаажуулна.)

Энэ хэсгээс доош нарийн бичиг бичнэ.

Хураалгасан огноо:

Цаг:

Нарийн бичгийн нэр, албан тушаал, цол:

Нарийн бичгийн гарын үсэг: